



**МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5, Утас: 26-15-53,
Факс: 32-86-34, Цахим шуудан: mlsp@mongolnet.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2017 09 25 № 1/2461
танай _____ -ны № _____ -т

**“Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх
Дэлхийн түншлэлд” нэгдэх тухай**

“Тогтвортой хөгжил- 2030” хөтөлбөр нь дэлхий нийтийн хөгжил цэцэглэлтийн төлөө бид бүхний хүлээсэн нийтлэг үүрэг бөгөөд даян дэлхийн бүх хүмүүсийн зөвлөлдөн гаргасан хүсэл тэмүүллийн илэрхийлэл билээ. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг бүх түвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд дэлхий нийтийн түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлсэн тохиолдолд амжилттай хэрэгжих юм.

Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх Дэлхийн түншлэл”, “Хүчирхийллийг эцэслэх” үзэл санаа, зарчмуудыг хүлээн авч, баталгаажуулж байгааг талархан мэдэгдэж байна.

Манай улс Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх бүхий л зорилт, үр дүн тухайлбал, 16.2 дахь зорилт “Хүүхдийн эсрэг дарангуйлал, хүүхдийн мөлжлөг, хууль бус наймаа, хүчирхийллийн бүх хэлбэр, хүүхдийг тарчлаан зовоох явдлыг зогсоох”; 5.2 дахь зорилт “Олон нийт болон хувийн хэвшлийн салбарт эмэгтэйчүүд, охидын эсрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тухайлбал хууль бус наймаа, бэлгийн болон бусад мөлжлөгийг устгах”; 16.1 дэх зорилт болох “Хүчирхийллийн бүх хэлбэр, түүнээс үүдэлтэй нас баралт, эндэгдлийн түвшинг дэлхий дахинд үлэмж бууруулах” зорилтыг бүрэн хэрэгжүүлэхээ амалж байна.

Түншлэлийн хүрээнд дараах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох талаар тэргүүлэх үйл ажиллагааг тодорхойлон, уялдуулахын тулд хууль зүй, боловсрол, эрүүл мэнд мэдээлэл харилцаа холбооны салбарууд болон бусад оролцогч талуудтай зөвлөлдөж, хамтран ажиллана;
2. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг батлан хэрэгжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөрт хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх талаар тодорхой зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ;
3. Хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг, хүчирхийллийг эцэслэхэд үндэсний түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Бид хамгаална” (WeProtect) загварыг ашиглаж, нөхцөл байдлыг үнэлнэ;


4. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэхэд шаардагдах хөрөнгө, нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна;

5. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх Дэлхийн түншлэлийг төлөөлөн "Хүчирхийллийг эцэслэх" талаар нөлөөллийн ажлууд зохион байгуулж, кампанит ажил өрнүүлнэ;

6. Хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэс болгохын тулд нотолгоонд тулгуурласан арга зам, туршлагыг тодорхойлж, хэрэгжилтийн талаар бүс нутгийн сургалт семинар, үйл ажиллагаанд оролцон, нийтэд мэдээлнэ.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас хүүхдийн эсрэг хүчирхийллийг эцэслэх улс төрийн хүсэл зоригийг бий болгох, суралцах, туршлагаас хуваалцах зорилгоор өндөр хөгжилтэй болон адил түвшний орны манлайлагчид, мэргэжилтнийг татан оролцуулах зэрэг үйл ажиллагааг санаачлан ажиллахаа илэрхийлж байна.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Н.НОМТОЙБАЯР